

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өвгөн	Дугаар	L339
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Адаацаг сум
Төрсөн газар	Адаацаг сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зуутын жас	Сүм хийдийн дугаар	ДУАЦ 026
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Энхбаяр



Дундговь аймгийн Адаацаг сумын Зуутын жас

Энхбаяр: Та тэгээд хэдэн настай лам болоов?

Өвгөн: Өө багадаа ер нь найман настай л сахил хүртсэн юм гэнэ лээ.

Энхбаяр: За хэдэн жил суусан тэгээд?

Өвгөн: Суусан юм байхгүй ээ, би чинь одоо тэгээд их хачин хүн ш дээ. Хотод нэг багш байсан юм. Тэгээд тэр багшаар багад нь ном заалгах гээд манай эцэг эх ярьсан юм. Найман наснаас нь ном заалгах гээ, одоо өнөө сургуулийн хүүхэд аятай. Тэгээд одоо найман настай нэг сахил хүртсэн болоод, багшийндаа тэгээд манай багш ч ер ном зааж өгдөггүй. Өөрөө бол жигтэйхэн эрдэмтэй, зоч чойжин, эмч мэргэн тийм эрдэмтэй лам байсан юм. Тэгээд надад одоо ер ном зааж өгдөггүй байсан юм. Тэгээд одоо яагаад ном зааж өгдөггүй байсан юм гэхээр би боддог юм аа. Одоо манайх чинь одоо, миний эхийн эцэг одоо баригдаж хоригдсон хүн. Тэгээд би цэрэгт явах гэж байлаа. Цэргээс ирээд л тван жил зургаан сар болж байгаад л тэгээд л халагдах болоод л. Тэгээд л эргэж хүрч ирээд л айлуудаар мал маллаж байна гээд л...

Энхбаяр: Та чинь одоо хэдтэй юм бэ? Хэдэн онд төрсөн юм?

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Өвгөн: Би тахиа жилтэй, одоо наян долоотой.

Энхбаяр: Зуутын дуганы тухай бол санах юм алга уу?

Өвгөн: За даа санах юм ч одоо... Дашрагчаа гээд нэг дуган байсан. Их жас гэж дуган, сахиусных гэж дуган байсан юм байх юм. Сандуйнх гэж байсан юм байх юм. Гүнригийн гэж, хайлангийн гэж нэлээн л хэдэн юм байсан.

Энхбаяр: Тэгээд энэ дуганууд чинь тусдаа жастай байсан уу?

Өвгөн: Өө тийм тийм. Бүгд тус тусдаа жастай байсан.

Энхбаяр: Энэ дуганууд юугаар баригдсан байсан бэ?

Өвгөн: Модон ч дуган байсан, тоосгон ч дуган байсан. Цогчин дуганыг модоор барьдаг байсан. Сахиусных туйлуу байсан. Сандуйнх ч бас модон дуган байсан.

Энхбаяр: Хоёулаа нэг бүдүүвч зурж үзэх үү? Энд цогчин дуган байсан гэж үзвэл?

Өвгөн: Энүүхэнд нь Сандуйн дуган байсан. Энэ ард нь Сахиусных байсан. За энд нь хайлангийн дуган байсан санагдана. Гүнригийн дуган гэж энэ хойно нэг шавар дуган байсан, за нэг иймэрхүү. Одоо өөр санаанд бүхгүй байна.

Энхбаяр: Одоо энэ туурин дээр нэг хана үлдсэн гэсэн ямар дуганых нь хана үлдсэн байна?

өвгөн: Одоо бол сахиусны дуган нь байгаа. Харин аль дуганых нь хана байсан билээ.

Энхбаяр: Цам ер нь яаж гардаг байсан ?

Өвгөн: Аа цам гарна. Яг хэдэн цамыг мэдэхгүй байна. Цагаан өвгөн, Хашин хаан тэгээд л хангалууд юу юу ч байлаа, тоог нь мэдэхгүй.Майдар хурна, ганжуур эргэнэ. Зун л майдар эргэдэг байсан санах юм.

Энхбаяр: Зоч лам байсан уу?

Өвгөн: Нэг их байгаагүй. Цэвээндорж гэж ганц зоч мундаг лам байсан юм. Дараа нь тэднийхний бас удмын нүд муутай, сохор Осор гэж зоч лам байсан юм. Тэр л зоч нарын сүүлчийнх нь болов уу, бараг. За тэгээд тэр үед чинь манайд яг бурхан багшийн шашин цэцэглэж байсан болохоор улааныхныг бас холхигүй гээд тиймээс зоч нар угаасаа цөөхөн байсан бололтой.

Энхбаяр: Хамба нь хэн гэж хүн байсан ?

Өвгөн: Жамба Тойн гэж хүн байсан юм.

Энхбаяр: Хамба лам гэж ер нь байсан юм уу,лоовон гэж байсан юм үү?

Өвгөн: Үгүй ээ одоо санахад яг хамба гэж байгаагүй, их лам л гэж байсан юм уу даа. Эхлээд манай энд том нь цорж лам гэж байсан юм. Тэгээд дараа ньЖамба Тойн гэж хүн болсон юм. Үгүй ээ, Тойн гэж манай эцэг хэлэхдээ тойн гэж язгууртан гаралтай лам хүнийг л тойн гэдэг юм гэж хэлж байсан шүү. Тойн гэдэг чинь дээр үеийн хятадын нэг зэрэг юм уу даа. Жаавтай тойн байсан юм гэнэ лээ. Тэр нь тийм ч их элбэг их цол хэргэм биш гэнэ лээ гэж ярьж байсан. Тэгээд сүүлдээ баригдаад явсан даа.

Энхбаяр: Хутагт хувилгаад гэж байв үү?

Өвгөн: Өө хутагт хувилгаад гэж байгаагүй.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энхбаяр: Тэгээд хэдэн онд энэ дуган хаагдсан бэ?

Өвгөн: За би чинь одоо 87-той, намайг 17, 18-тай байхад ер нь 17-той л байхад хаагдсан юм.

Энхбаяр: За тэгэхээр 1937 оны үед л юм даа?

Өвгөн: За тийм болж байна уу.

Энхбаяр: Энэ хурлын шүтээн сахиус нь ямар бурхан байсан бэ?

Өвгөн: Гомбо сахиустай.

Энхбаяр: Та аль дуганд хурдаг байсан?

Өвгөн: Өө тэгээд л энд тэнд, дуган дамжаад л хурдаг байсан. Намайг 16-тай байхад 17, 18 настай шавь хүүхдүүдийг Шаавай лам гэж лам дагуулан энэ цагаан овоо гэж байсан юм. Тэнд дагуулж аваачин, үзсэн номоор шүүлэг авч нэг хүүхэд л тэнцэж ирж байсан юм. Би яваагүйг бодоход 16-тай байсан. Дараа жил нь шүүлэгт явах байсан юм.

Энхбаяр: Тахидаг уул овоо нь ямар уул овоо байв?

Өвгөн: За энэ хойд Тойн уулыг тахина. Наана нь Хонгорын овоо гэж бий. Тэрнийг тахидаг байсан. Цам гарахад Тойн уулын савдаг гээд тийм нум сум агссан ширүүн дүртэй дошгин баг гардаг байсан санагдана.

Энэхүү нар дурдсан хүний амьтан ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцлагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. © Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

3